



ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 ОНЫ ЭХНИЙ 6 САРЫН БАЙДЛААР

Дархан-Уул аймаг

Эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд
/2024, 2025 оны эхний 6 сарын байдлаар/

№	Үзүүлэлт		Нэгж	2024 он	2025 он	Өсөлт бууралт	Улсын дундаж	
1	Төрсөн эх		Бодит тоо	905	894	-11	22375	
2	Амьд төрсөн хүүхэд		Бодит тоо	905	904	-1	22556	
3	Амьгүй төрсөн хүүхэд		Бодит тоо	5	1	-4	104	
			1000 нийт төрөлтөд	5.5	1.1	4.4	4.6	
4	Эхийн эндэгдэл		Бодит тоо	0	2	0	9	
			100 000 амьд төрөлтөд	0.0	221.2	221.1	34.9	
5	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		Бодит тоо	8	13	+5	377	
			1000 амьд төрөлтөд	8.8	14.3	+5.5	16.7	
6	Үүнээс:	Нялхсын эндэгдэл /0-364 хоног/	Бодит тоо	6	9	+3	320	
			1000 амьд төрөлтөд	6.6	9.9	+3.3	14.2	
		Үүнээс:	Нярайн эндэгдэл /0-28 хоног/	Бодит тоо	5	7	+2	256
				1000 амьд төрөлтөд	5.5	7.7	+2.2	9.3
8	Нийт нас баралт		Бодит тоо	245	269	+24	7219	
9	Эмнэлгийн нас баралт		Бодит тоо	106	122	+16		
			Хувь	43.3	45.4	+2.1	34.1	
10	Эмнэлэгт хоног болоогүй нас баралт		Бодит тоо	29	35	+6		
			Хувь	11.8	13.0	+1.2	21.2	
11	Жирэмсний эрт		Хувь	96.9	96.6	-0.3	93.5	
12	Эмчлэгдсэн хүний		Бодит тоо	7239.2	7539.5	300.3	424842	
13	Нийт Ор хоног		Бодит тоо	75471	93476	+18005	2835111	
	Дундаж ор хоног		Хувь	7.0	6.9	-0.1	6.7	
14	Нийт Халдварт өвчин		Бодит тоо	876	636	48	22597	
			10 000 хүнд	80.2	61.1	19.1	63.7	

1. Эх, хүүхдийн эрүүл мэнд

Төрөлт

Дархан-Уул аймагт 2025 оны эхний 6 сарын байдлаар 894 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 11 төрөлтөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

Төрсөн эхчүүдийн нь 802 буюу 89.7 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан байна. Нийт төрөлтөөс Амьгүй төрөлт 1 тохиолдол буюу 0.1 хувь өмнөх үеийн мөн үетэй харьцуулахад 4.4 промилль буурсан. Гэрийн

төрөлт 2 тохиолдол буюу 0.2 хувь эзэлж байгаа бөгөөд урьд оны мөн үетэй харьцуулахад 0.2 промилиор буурсан үзүүлэлтэй байна.

2025 оны эхний 6 сарын байдлаар мэс заслын аргаар төрсөн эхчүүд 18.2 хувийг эзэлж байгаа ба 14.1 хувь нь төрөлтийн хүндрэлтэй, 85.9 хувь нь хүндрэлгүй төрсөн байна. Нийт төрсөн эхчүүдээс жирэмсний хүндрэлтэй 279 буюу 31.2 хувь, төрөх үеийн хүндрэл 241 буюу 26.9хувь, төрсний дараах хүндрэл 7 буюу 0.7 хувь , тус тус эзлэж байна.

Хүүхдийн эрүүл мэнд

2025 оны эхний 6 сарын байдлаар Дархан-Уул аймагт 904 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 1 хүүхдээр буюу 0.1 хувиар буурсан. Төрөлтийн түвшин 1000 хүн амд 41.7 байна.

Амьд төрсөн хүүхдийн 458 буюу 50.6 хувь нь хүү, 446 буюу 49.1 хувь нь охин байна.

Амьд төрсөн нийт хүүхдээс 33 нярай буюу 3.6 хувь нь 2500 грамаас доош жинтэй, 4 тохиолдол буюу 0.4 хувь нь төрөлхийн гажигтай төрсөн байна. Төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 98.1 байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 төрөлтөд 1.1 байна.

Хүснэгт 1.2. Төвийн бүс, Амьд төрсөн хүүхэд, эхийн тээлтийн хугацаа, хувиар

№	Аймаг/хот	Эхийн тээлтийн хугацаа эзлэх хувь					Төрөлхийн гажигтай төрсөн	2500 гр-аас доош жинтэй төрсөн хүүхэд
		22-28	29-32	33-36	37-41 долоо хоногтой	42 долоо хоногтой с дээш		
		долоо хоногтой	долоо хоногтой	долоо хоногтой				
A	Б	1	2	3	4	5	6	7
1	Дархан-Уул	0.8	0.3	3.9	94.4	0.7	0.7	0.5
2	Говьсүмбэр	0	0	3.4	96.6	0	1	0.8
3	Дорноговь	0	0.3	2.4	96.8	0.6	1.1	0.9
4	Дундговь	0	0	3.1	96.9	0	0.6	0.4
5	Өмнөговь	0.6	0.6	5.8	92.9	0	0.3	0.4
6	Сэлэнгэ	0	0.9	6.1	93.0	0	0	0.0
7	Төв	0.4	0.4	6.0	93.3	0	0	0.7
8	Аймгийн дундаж	0.3	0.6	4.1	94.9	0.1	0.7	0.7
10	Улсын дундаж	0.4	1.1	5.7	92.6	0.1	0.8	0.7

2025 оны эхний 6 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад өссөн дүнгээр 43151 хүүхэд хамрагдсанаас 0.1 хувь нь туранхай, 0.02 хувь нь тураалтай, 0.09 хувь нь өсөлтийн хоцрогдолтой, А амин дэм уусан 1.44 Д амин дэм уусан 89.1, олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн 0.9 хувьтай байна.

Хүснэгт 1.3. Тав хүртэлх насны хүүхдийн жингийн мэдээ, хувиар

№	Аймаг/хот	Бүгд	Жингийн мэдээ			А амин дэм уусан	Д амин дэм уусан	Олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн
			Туранхай	Тураалтай	Өсөлтийн хоцрогдолтой			
А	Б	1	2	3	4	5	6	7
7	Дархан-Уул нийт	43151	0.1	0.02	0.09	1.44	89.1	0.9
8	Дархан сум	40511	0.10	0.02	0.10	1.2	90.6	0.2
9	Шарын гол сум	1322	0.5			3.4	88.5	
10	Хонгор сум	1119				4.4	45.8	22.9
11	Орхон сум	198				6.5	27.7	19.6
22	Аймгийн дундаж	374508	0.17	0.13	0.18	9.91	53.6	2.60
24	Улсын дундаж	746861	0.15	0.11	0.15	11.8	44.2	1.75

Эхийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар эхийн эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдэж, 100000 амьд төрөлтөд 221.2 ногдож байна. Сүүлийн 10 жилийн дундажаар 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 48.1 байна.


Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд

№	аймаг	2016 он	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025 он 6 сар	10 жилийн дундаж
1	Дархан-Уул	40.2	0	83.1	0	0	136.7	0	0	0	221.2	48.1
2	Аймаг	56	22.3	24.4	21.6	32.9	70.9	42.8	13.3	22.8	58.0	35.1
3	Улс	48.6	26.9	27.1	23	30.2	94.9	35.1	26.4	22.5	39.9	36.9

Нялхсын эндэгдэл

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 9 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 9.9 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 тохиолдлоор буюу 3.3 промиллоор өссөн үзүүлэлттэй байна.

Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд




Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Аймагийн хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 13 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 14.3 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 тохиолдлоор буюу 5.5 промиллор өссөн үзүүлэлтэй байна.

Нийт тохиолдлын 4 буюу 30.7 хувь нь эмнэлгээс гадуур, 9 тохиолдол буюу 69.3 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс хоног болоогүй нас баралт баралт бүртгэгдээгүй байна. Шалтгаанаар авч үзвэл: Нийт эндэгдлийн 92.3 хувь нь өвчнөөр, 7.7 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн байна.

Төвийн бүсийн аймгуутай харьцуулбал: 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл




ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Амбулаторийн тусламж үйлчилгээ

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар нийт 363634 эмчийн үзлэг хийгдсэнээс 28.9 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 48.6 хувийг өвчний учир амбулаторт, 8.1 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 13.9 хувийг гэрийн идэвхитэй эргэлт тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өвчний учир амбулаторийн үзлэг 1.6 хувиар буурч, урьдчилан сэргийлэх үзлэг 1.7, хувиар өссөн идэвхитэй хяналт болон гэрийн үзлэгийн хувь ижил түвшинд байна.

	ЭМБ-ууд	Нийт үзлэг	Үүнээс				
			Урьдчилан сэргийлэх үзлэг	Амбулаторийн үзлэг	идэвхитэй хяналт	гэрийн идэвхтэй хяналт	гэрийн дуудлага
2024 он 36 сараар	Нэгдсэн эмнэлэг	128324	18714	98157	11444		9
	СЭМТ-үүд	24685	11755	6664	1501	4700	65
	ӨЭМТ-үүд	138257	67785	8899	15130	44205	1098
	ХХЭМБ-ууд	68161	3875	64286			
	Аймгийн дүн	359427	102129	178006	28075	48905	1172
2025 он 6 сараар	Нэгдсэн эмнэлэг	119843	15395	88751	15695		2
	СЭМТ-үүд	28860	15827	5879	1611	5515	28
	ӨЭМТ-үүд	137393	67946	10864	12330	45334	919
	ХХЭМБ-ууд	77538	6021	71517			
	Аймгийн дүн	363634	105189	177011	29636	50849	949

Эмчийн үзлэг төрлөөр, хувь



Амбулторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан 10 000 хүн амд

2025 оны 2-р улирлын байдлаар

Оношоор	Тохиолдлын тоо	10 000 хүн амд	нийт тохиолдлын хувь
Амьсгалын эрхтэн тогтолцоо	12294	1182.8	32.4
Хоол шингээх тогтолцоо	5870	567.7	15.5
Нүд ба түүний дайврын өвчнүүд	4427	425.9	12.2
Цусны эргэлтийн тогтолцоо	2599	250.0	6.9
Шээс бэлэгсийн тогтолцоо	2881	277.1	7.6
Арьс ба халимны өвчин	2759	265.4	7.2

Хорт хавдрын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан

Зонхилох зургаан байрлалын хорт хавдар, хүйсээр

Нийт				Эрэгтэй хүйс			Эмэгтэй хүйс		
	Хорт хавдар	T/тоо	Хувь	Хорт хавдар	T/тоо	Хувь	Хорт хавдар	T/тоо	Хувь
1	Элэг	34	23.8	Элэг	24	32.9	Умайн хүзүү	10	14.3
2	Ходоод	30	21.0	Ходоод	24	32.9	Элэг	10	14.3
3	Умайн хүзүү	10	7.0	Уушиг	5	6.8	Хөх	13	18.6
4	Хөх	13	9.1	Улаан хоолой	4	5.5	Бамбайн булчирхай	4	5.7
5	Уушиг	5	3.5	Түрүү булчирхай	3	4.1	Бүдүүн шулуун гэдэс	7	10.0
6	Улаан хоолой	7	4.9	Бүдүүн шулуун гэдэс	3	4.1	Ходоод	6	8.6
7	Бусад байрлал	44	30.8	Бусад байрлал	10	13.7	Бусад байрлал	27	38.6
	Нийт	143			73			70	

Эрэгтэйчүүдийн дунд элэг (32.9%), ходоодны (32.9%), хорт хавдар эхний хоёр байранд, уушиг (6.8%) , улаан хоолойн (5.5%) хорт хавдар гуравдах байранд, зонхилон тохиолдох эхний 6 байрлалын хорт хавдрын өвчлөлд түрүү булчирхай, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын өвчлөл удаалж байна.

Эмэгтэйчүүдийн дунд хөхний хавдар нэгд (18.6%), умайн хүзүүний хавдар (14.3%), элэг (14.3%) хорт хавдар хоёр, гуравдугаар байранд, бамбайн булчирхай, ходоод, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын өвчлөл удаалж байна.

Халдвар бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Аймгийн хэмжээнд артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны хамрагдвал зохих 66082 иргэнээс хамрагдсан 34092/51.6/ иргэн хамрагдсан бөгөөд эрэгтэй 43.0 хувь, эмэгтэй 57.0 хувьтай байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт үзлэгийн 0.2хувь нь артерийн гипертензи онош батлагдсан. Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш нийт 31362/ 47.4/ иргэн хамрагдсан бөгөөд эрэгтэй 42.0 хувь, эмэгтэй 58.0 хувьтай байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт үзлэгийн 0.03 хувь нь чихрийн шижин онош батлагдсан.

Эрт илрүүлэгийн хамрагдалтын хувь батлагдсан тохиолдол өрх сумаар

ЭМБ-ууд	Артерийн гипертензи эрт илрүүлэг хамрагдалт				Чихрийн шижин эрт илрүүлэгт хамрагдалт		
	Хамрагдвал зохих 18+	Хамрагдсан хүний тоо	хамрагдалтын хувь	оношлогдсон артерийн гипертензи	Хамрагдсан хүний тоо	хамрагдалтын хувь	оношлогдсон чихрийн шижин
Шарын гол сум	4747	1395	29.4	3	1683	17.2	1
Хонгор сум	3717	1378	37.1	9	1163	16	
Орхон сум	2103	1030	49		858	10.9	
Аминхолбоо	9048	4962	54.8		5094	29.6	2
Гэрэлтэй	7464	4490	60.2	9	4427	15	2
Гос-хот	19761	10738	54.3	41	9606	27.3	1
Түвшин-холбоо	7563	4415	58.4	8	3825	15.3	3
Мэдс-тоб	11679	5684	48.7	8	4706	19.3	2
Дархан-Уул аймаг	66082	34092	51.6	78	31362	47.4	11
Улс		646086	33.1		527704	40.6	

Хөх умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын байдал эхний 6 сараар:

Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 7637 эмэгтэй хамрагдахаас 2970 буюу 38.6 %, хөхний эрт илрүүлэгт 27398 эмэгтэй хамрагдахаас 18648 буюу 68.1% хамрагдсан байна.

Жирэмсний хяналт

2025 оны эхний 6 сарын байдлаар шинээр жирэмсний хяналтанд хамрагдсан 946 эмэгтэй байгаас эхний 3 сартайд 914 буюу 96.6 хувь хяналтанд орж урьд оны мөн үеэс 0.3 хувиар буурсан. Хяналтанд орсон эмэгтчүүдээс 26 буюу 4.5 хувь нь цус багадалт илэрсэн байна.

Жирэмсний эрт үеийн хяналт өрх сумаар / улс аймгаар /

ЭМБ-ууд	Шинээр жирэмсний хяналтанд орсон тоо	эхний 3 сар хувь	цус багадалт хувь
Амин холбоо	162	98.8	
Гэрэлтэй	118	100	
Гос-хот	305	95.7	7.7
Түвшин холбоо	82	95.1	4
Мэдс-тоб	177	96.6	11.4
Шарын гол	50	82.0	
Хонгор	37	100	
Орхон	15	86.6	
Аймаг	946	96.6	5.1
Улс	22976	93.5	4.1

Шинээр жирэмсний хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдээс трихомониаз 12 буюу 1.2 хувь, тэмбүү 3 буюу 0.3 хувь, заг хүйтэн 1 тохиолдол буюу 0.1хувь, тус тус эерэг гарсан байна.

Үр хөндөлт

Аймгийн хэмжээнд 2025 оны 2-р улирлын байдлаар нийт 176 эмэгтэй үр хөндөх мэс ажилбар хийлгэсэн ба өмнөх оны мөн үеэс 36 тохиолдлоор буурсан үзүүлэлтэй байна. 20 хүртэлх насны үр хөндөлт 6 буюу 3.4 хувь, хожуу үр хөндөлт 7 тохиолдол бүртгэгдэж 3.9 хувь эзлэж байна.

Түргэн тусламжийн дуудлага

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар нийт 8366 дуудлага бүртгэгдэж, өмнөх оноос 198 тохиолдлоор өссөн боловч алсын дуудлага 245 тохиолдол буюу 2.9 хувиар , осол гэмтлийн дуудлага 935 тохиолдол буюу 11.1 хувиар тус тус өссөн үзүүлэлтэй байна.

	түргэн тусламжийн дуудлага			Алсын дуулагын эзлэх хувь	Осол, гэмтлийн дуудлагын эзлэх хувь
	Нийт	Алсын дуудлага	Осол гэмтлийн дуудлага		
2024 оны 2-р улирал	8168	202	797	2.4	9.7
2025 оны 2-р улирал	8366	245	935	2.9	11.1
Өсөлт бууралт	+198	+43	+138	+0.5	+1.4

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Хэвтэн эмчлүүлэгчдийн тусламж үйлчилгээ Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар 13776 үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 93476 ор хоног ашигласан байна. Улсын дунджаар ор ашиглалтын хувь 64.3, дундаж ор хоног 6.7 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэвтэн эмчлүүлэгч 2335 хүнээр, ор хоног 18549 тохиолдлоор тус тус буурсан байна.

№	ЭМБ-ууд	Орны тоо	Эмчлэгдсэн өвчтөн	Эмнэлэгт хэвтсэн Бүгд	Эмнэлгээс гарсан.	Ор хоног	Орны фонд ашиглалт	Дундаж ор хоног	Орны эргэлт
1	Нэгдсэн эмнэлэг	419	8034.5	8125	8066	55334	122.0	6.8	19.3
2	Шарын гол сум	33	552.5	547	558	4005	116.3	7.2	16.5
3	Хонгор сум	14	251.0	250	252	1764	126.0	7.0	17.8
4	Орхон сум	13	203.5	205	202	1376	98.2	6.7	15.7
5	ХХЭМБ-ууд	364	4619.0	4649	4589	30997	85.1	6.7	12.7
6	Дархан-Уул Аймаг	843	1372.1	13776	13667	93476	97.7.8	7.0	14.4
	Улс	29443		256063		1727622	94.1	6.7	14.3

Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан 10 000 хүн амд
2025 оны 2-р улирлын байдлаар

Оношоор	Тохиолдлын тоо	10 000 хүн амд	нийт тохиолдлын хувь
Амьсгалын тогтолцоо	2232	120.4	16.3
Цусны эргэлтийн тогтолцоо	1698	87.9	12.4
Мэдрлийн тогтолцооны эмгэг	1023	57.4	7.5
Хоол шингээх тогтолцоо	1155	55.7	8.4
Яс булчин	1013	50.8	7.4
Шээс бэлэгсийн тогтолцоо	899	45.2	6.5

Хүн амын нас баралт

2025 оны 2-р улирлын байдлаар аймгийн хэмжээнд нас баралт 269 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн үеийн мөн үеэс 24 тохиолдлоор өссөн. Нийт нас баралтын 45.4 хувь нь эмнэлэгт, үүнээс 35 тохиолдол буюу 13.0 хувийг хоног болоогүй нас баралт эзлэж байна. Хоног болоогүй нас баралт 6 тохиолдлоор өссөн үзүүлэлтэй байна.

	Нийт нас баралтын тохиолдол	Эмнэлгийн нас баралтын эзлэх хувь	Хоног болоогүй нас баралтын эзлэх хувь	Гэрийн нас баралт эзлэх хувь
2024 оны 2-р улирал	245	43.3	11.8	56.7
2025 оны 2-р улирал	269	45.4	13	54.6
Улс 2-р улирал	4562	34.1	21.2	

Осол гэмтлийн шалтгаан нас баралт :

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 27 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 10.0 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 12 тохиолдлоор өссөн бөгөөд 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 2.5 байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтад эзлэх хувь

Үзүүлэлт	Осол гэмтлийн шалтгаант нийт нас баралт	Амиа хорлолт	бусдад хорлогдсон	Үйлдвэрийн осол	Зам тээврийн осол	Бусдад осол	Шалтгаан тодорхойгүй
2024 оны 2-р улирал	15	13.3	0	6.7	13.3	66.7	0
2025 оны 2-р улирал	27	11.1	4.3	0	21.7	56.5	13
Улс 2025 оны 2-р улирал	1287	18.6	7.2	0.4	14.2	56.1	3.5

Хорт хавдрын шалтгаант нас баралт

2025 оны эхний 6 сарын байдлаар хорт хавдрын шалтгаан нас баралт 84 тохиолдол бүртгэгдэж урьд оны мөн үеэс 15 тохиолдлоор өссөн нийт нас баралтын 31.2 хувь эзлэж, нас баралтын 2 дахь шалтгаан болсон хэвээр байна.

Халдварт өвчин

Аймгийн хэмжээнд 636 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 61.1 ноогдож, өмнөх оны мөн үеэс 231 буурсан үзүүлэлтэй байна.

Нийт халдварт өвчин 10 000 хүн амд

		2024 оны 2-р улирал	2025 оны 2-р улирал
Дархан-Уул аймаг	Нийт халдварт өвчин	867	636
	10 000 хүн амд	83.4	61.1
Улсын дүн	Нийт халдварт өвчин	18514	22597
	10 000 хүн амд	52.8	63.7

Халдварт өвчний тохиолдол, нас баралт, төрлөөр

№	Халдварт өвчин	Өвчлөл			нас баралт		
		2024 он 6 сар	2025 он 6 сар	Өсөлт бууралт	2024 он	2025	Өсөлт бууралт
1	Амьсгалын замын халдварт өвчин	418	448	+30			
2	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин	100	108	+8			
3	гэдэсний халдварт өвчин	185	67	-118			
4	Зоонозын халдварт өвчин	0	2	+2			
5	Цусаар дамжих халдварт өвчин	3	7	5			
6	Бусад халдварт өвчин	161	4	-157			
Нийт халдварт өвчин		867	636	-231	0	0	0

Тайлан боловсруулсан:

СТА мэргэжилтэн: Б.Мөнхзул